

**УЛС ТӨРИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ БҮТЭЦ  
БҮРЭЛДЭХҮҮН**

**УЛС ТӨРИЙН ИНСТИТУТУУДЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА, ЧИГ ҮҮРЭГ**

**УЛС ТӨРИЙН НАМУУД**

# ТУЛГУУР ОЙЛГОЛТ

**Улс төрийн систем** бол нийгэмд засаглалыг зохион байгуулан, нийгмийн баялгийг хуваарилан байршуулах арга хэрэгслүүд, эрх зүйн болон улс төрийн хэм хэмжээ, дэг журмын цогц, төр, иргэд нийгмийн байгууллагуудын нэгдэл юм.

**Сонирхлын бүлэг** нь улс төрийн үйл явцын үндэс нь сонирхлын бүлгүүдийн зөрчилдөөн, харилцан үйлдэл байдаг, тэдгээр бүлгүүдийн үйл ажиллагаа нь өөрсдийн хүсэл сонирхлыг засгийн газарт тулган хүлээлгэх зорилгоор дарамт шахалт үзүүлэх явцдаа байнга өөрчлөгдөж байдаг үйл явц.

**Улс төрийн нам** гэдэг нь үзэл бодлоороо эвлэлдэн нэгдсэн бөгөөд засгийн эрхийг авах эцсийн зорилготой хэсэг бүлэг хүмүүсийн нэгдэл, улс төрийн байгууллага ЮМ



Улс төрийн системийн загвар-  
Д.Истон




Улс төрийн системийн загвар-  
Г.Алмонд



Улс төрийн системийн  
бүрдэл

Улс төрийн системийн дэд  
бүтэц ??????





# I. ТОГТОЛЦООНЫ (ИНСТИТУЦИОНАЛЬ) ДЭД СИСТЕМ

Системийн хандлага нь аливаа үзэгдэл бие даасан байх авч өөр бусадтай харилцан хамааралтай бөгөөд өөрийн онцлог орчин бүхий нэгэн бүхэллэгийг үүсгэн хөдөлгөөнт шинжтэй байна гэдгийг үндэс болгодог. Аливаа систем «оролт», «хувиралт», «гаралт», «эргэх холбоо» гэсэн хэсгээс бүрддэг ба улс төрийн системийн хувьд «оролт» нь олон түмний шаардлага, дэмжлэг, «гаралт» нь шийдвэр, үйлдэл юм.

## II. МЭДЭЭЛЭЛ-ХАРИЛЦААНЫ ДЭД СИСТЕМ

Мэдээлэл-харилцааны дэд систем нь улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох, төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах «сувгийн» үүрэг гүйцэтгэдэг.

Улс төрийн системийн үйлчлэл нь хүмүүсийн авч буй мэдээллийн түвшин, хүрээнээс ихэд шалтгаалдаг.

Хүмүүс тодорхой мэдээлэл, мэдлэгтэй байж л улс төрийн аливаа үйлдлийг үнэлэх боломжтой байдаг.



## III. ХЭМ ХЭМЖЭЭ-ЗОХИЦУУЛАЛТЫН ДЭД СИСТЕМ

---

- Улс төрийн амьдрал дахь хүмүүсийн үйл байдал болон бусад объектын чиг үүргийг тодорхойлох хэм хэмжээнээс бүрдэнэ.
- Хэм хэмжээг: дадал заншлын, хууль зүйн гэж ангилна. Ардчилсан нийгэмд улс төрийн нам, сонирхлын бүлгээр дамжин улс төрийн амьдралд оролцох хүмүүсийн оролцоог заншлын хэм хэмжээ гэж үзнэ. Нөгөө талаас төрийн зүгээс ч анхаарал халамж хүсэх явдал иргэдийн хувьд мөн хэвшсэн ердийн үзэгдэл юм.

# УЛС ТӨРИЙН СИСТЕМИЙН ЧИГ ҮҮРЭГ

**Сонирхол илэрхийлэх үйл ажиллагаа** - нийгмийн гишүүд үнэт зүйлсийг байршуулах талаар өөр өөрийн сонирхолтой, тэр сонирхлоо хэрэгжүүлэхийг эрмэлзэж янз бүрийн арга хэрэгслийг ашиглан шийдүүлэхийг хичээж буй үйл ажиллагаа.

**Сонирхолыг нэгтгэх үйл ажиллагаа** - сонирхол янз бүр, заримдаа хоорондоо эсрэг тэсрэг байх ба түүнийг хангах арга замыг тодорхойлон бодлого боловсруулах үйл ажиллагаа.

**Сонирхолыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа** - бодлогыг нийтээр дагаж мөрдөх шийдвэрт тусгуулж, түүнийг улс төрийн засгийн эрх мэдлээр биелүүлэх үйл ажиллагаа эдгээр болно.



**Сонирхлын бүлгийн онолыг анх Америкийн улс төр судлаач  
А.Бентли Д.Трумен нар дэвшүүлсэн юм.?????????**


## **СОНИРХОЛ ИЛЭРХИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ЧИГ ҮҮРГЭЭР ИЛЭРНЭ**

- **СОНИРХЛЫН АГРЕГАЦИ** (interest aggregation)- сонирхол, шаардлагыг нэгтгэн бодлого боловсруулах үйл явц.

**СОНИРХЛЫН АРТИКУЛЯЦИ** (interest articulation)- нь нийгэмд янз бүрийн сонирхол, шаардлагыг илрүүлэн гаргах үйл явц.

- **СОНИРХЛЫН ИНТЕГРАЦИ** нь нийгэмд янз бүрийн сонирхол, шаардлагыг нэгтгэх үйл явц.

# СОНИРХОЛ ИЛЭРХИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА





## СОНИРХЛЫН БҮЛГҮҮД ОЛОН АРГА ЗАМААР ЗОРИЛГОО ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

- Асуудлаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж, ард түмний дэмжлэгийг авсны үндсэн дээр парламентаар хялбархан шийдвэрлүүлэх,
- Том хэмжээний эсэргүүцлийн жагсаал цуглаан зохион байгуулах,
- Ямар нэгэн асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд нам эрх бүхий албан тушаалтанд сонгуулийн болоод бусад үед санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсвэл үзүүлэхгүй гэдгээ илэрхийлэх,
- Мэдээллийг хянаж түүнд дүн шинжилгээ хийх,
- Заргалдах (Энэ тактикийг ихэвчлэн хүч султай сонирхлын бүлгүүд ашигладаг) зэрэг арга замууд нэлээд түгээмэл байна.



## УЛС ТӨРИЙН НАМЫН ҮҮСЭЛ



*Зураг 5.6. Английн хувьсгалын үйл явц*

Түүхэн үүднээс намын үүслийг XVII зууны сүүл XVIII зууны эхэн үед хамааруулдаг. Энэ үед Баруун Европ, АНУ-д засаглалын шинэ харилцаа бүхий улс төрийн систем үүсэж эхэлсэн түүхтэй. Иймд улс төрийн намын үүсэл нь Франц, Английн хувьсгалууд, АНУ-ыг байгуулах тэмцэл, хөдөлгөөн зэрэгтэй холбогддог. Бүгд найрамдах төрийн шинэ хэлбэр тогтох үйл явцад олон нийтийг төлөөлөх, засаглалыг зохион байгуулах байгууллага үүссэн нь улс төрийн нам юм.



# УЛС ТӨРИЙН НАМЫН ҮҮРЭГ

Нийгмийн үүрэг - иргэдийн ашиг сонирхлыг нэгтгэн тодорхойлохыг эрмэлздэг бөгөөд тэдний хүсэл зоригоо илэрхийлэх арга замыг "зааж" өгөн тэдний шаардлагыг тодорхой зохих түвшинд гаргадаг (хурал, жагсаал, цуглаан зохион байгуулахаас эхлээд хувьсгалд уриалан дууддаг).

Үзэл суртлын үүрэг - нийт нийгмийн гишүүд болон өөрийн гишүүддээ улс төрийн тодорхой үзэл баримтлалыг санал болгож итгэл үнэмшил болгосноор өөрсдийн боловсруулсан нийгмийн өөрчлөлтийн стратегиа дэмжүүлэх.

Улс төрийн үүрэг (Сонгуулийн үүрэг, Удирдлагын үүрэг) - төрийн сонгуульд оролцож засаглах эрх мэдэл болон түүнд оролцох эрх авах, төрийн бодлогыг тодорхойлох, төрийн албан тушаалд өөрсдийн хүмүүсийг бэлтгэн байршуулах.

Ард түмний эрх ашигт нийцүүлэн ажиллах

# УЛС ТӨРИЙН НАМЫН АНГИЛАЛ



Нэг намын тогтолцоо
Хоёр намын тогтолцоо
Олон намын тогтолцоо

Нэг намын тогтолцоо

Хоёр намын тогтолцоо

Олон намын тогтолцоо





Зураг 5.9. 2012 онд УИХ-д суудал авч байсан зарим намын бэлгэ тэмдэг

# Олон намын тогтолцооны ач холбогдол

Олонхын дэмжлэг авсан улс төрийн нам засаглалыг хэрэгжүүлдэг.  
Цөөнхийн дэмжлэг авсан нам нь эрх баригч намыг хянаж ажилладаг.  
Нэг нам ноёрхох боломжийг хязгаарладаг.  
Засаглалын тэнцвэрийг хадгалах нөхцөл бүрддэг.  
Олон ургалч үзлийг дэмждэг.  
Хүний эрхийг хангадаг гэх мэт.

Монгол улсад 1990 оны 05 дугаар сарын 10-нд анх Улс төрийн намуудын тухай БНМАУ-ын хууль батлагдан МАХН, МҮДН, МЧХН, МоАН, МСДН, МНН-уудыг тус тус албан ёсоор бүртгүүлж, улс төрийн үйл ажиллагаа явуулах эрхийг олгосон байдаг. Ингэж гурав дөрөвхөн сарын өмнө ганц МАХН-тай байсан Монгол улсад улс төрийн олон нам улсын Дээд Шүүхэд бүртгүүлж, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн байна.

## ГЭРИЙН ДААЛГАВАР

---

- Үйл ажиллагаа 5.12 ажиллах Сурах бичиг 160 хуудас
- Үйл ажиллагаа 5.12 ажиллах Сурах бичиг 160 хуудас
- Асуултад хариулах Сурах бичиг 165 хуудас